



Хархорин ХК

2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Хархорин ХК

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ, ХАРХОРИН СУМ, ЭРДЭНЭ-ТОЛГОЙ БАГ, УСЖУУЛАХ 00 |
УТАС: 99993800

АГУУЛГА

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НЭР, ОРШИН БАЙГАА ХАЯГ:	2
2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:.....	2
3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	2
4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ, ТУХАЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЭЛЖ БУЙ БАЙР СУУРЬ, СУДАЛГАА.....	2
5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ТОМООХОН ӨӨРЧЛӨЛТ, ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮСЧ БОЛОХ ЭРСДЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАНИЛЦУУЛГА:.....	4
7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ 5 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИЙГ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:.....	4
8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2021 ОНЫ 2-Р УЛИРЛЫН БАЙДЛААР)	5
8.1. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд.....	5
8.2. “Хархорин” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн тухай	6
8.3. Татварын тайлангийн тухай (2021 оны 2-р улирлын байдлаар):.....	13
9. КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	13
10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	13
11. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ШИЙДВЭР	14
12. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУЗ-ИЙН ШИЙДВЭРҮҮД.....	16
13. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	17

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Хархорин ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ-толгой баг, Усжуулахын контор

Утас: 99993800, 95953170

Факс: 70151955

Электрон хаяг: ganbat.battogtokh@gmail.com

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

1.	Оноосон нэр	Хархорин
2.	Хариуцлагын хэлбэр	Нээлттэй Хувьцаат Компани
3.	Регистрийн дугаар	2015471
4.	Улсын бүртгэлийн дугаар	1010001006
5.	Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.29
6.	Үндсэн эрхлэх үйл ажиллагаа	Чацаргана тариалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн зорилго: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэгч, чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болох.

Үйл ажиллагааны стратеги: “Хархорин” ХК нь Монгол Улсад төдийгүй дэлхийд томоохонд орох нийт 3,000 гаруй га талбай бүхий чацарганы “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 2007 – 2020 онд нийт 600 гаруй га талбайд чацаргана тариалаад байгаа бөгөөд чацарганы ургацын хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа

“Хархорин” ХК нь Монгол Улсын эртний нийслэл Хархорин хот, одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Хархорин сум нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Өвөрхангай аймгийн төвөөс зүүн хойш 130 км зайд оршдог.

“Хархорин” ХК нь анх 1956 онд БНМАУ-ын Засгийн газрын 100% хөрөнгө оруулалтаар Хархорин сум САА нэртэйгээр газар тариалан, мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй Монголын томоохон САА нэг юм. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал гарч ирсэнээр 1992 онд тус САА нь Хархорин ХК нэртэйгээр төрийн өмч хувийн өмчид шилжин 70% төр, 30% тухайн нутгийн ард иргэдэд өмчлөн холимог системээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 оноос тус компанийн хэвийн ажиллагаа доголдож 2007 онд өмч хувьчлал буюу нээлттэй тендэр зарлан 100%, хувийн өмчид шилжсэн. Шилжсэн цагаас хойш тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн Монгол Улсын

засгийн газраас баталсан “Чацаргана”, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд, чацаргана үржүүлэх, тариалах чиглэлээр нийт 100 гаруй байнгын ажилтан ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Ерөнхий агрономич Л.Бямбасүрэнгээр ахлуулсан 6 бригад, бригадыг ахалсан мэргэжлийн 6 агрономичтойгоор агро үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компанийн эзэмшлийн газар нутгийн хувьд 4000 гаруй га талбай, Орхон голоос эх авсан усалтын 13 м сувагтай 2007 оноос эдүүгээ нийт 600 гаруй га талбайд чацарганы жимст цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай байгуулан ажиллаж байна. Мөн 2014 он ОХУ-аас гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, алим гэх мэт төрлийн жимслэг ургамлыг нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хархорин” ХК нь Монгол Улсад хамгийн томд орох таримал чацарганы талбайтай бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд жилд нийт 1,250 гаруй тонн чацарганы жимс хураан авч дотоодын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүчин чадалтай.

Монголын Чацарганы холбооноос авсан мэдээллээр одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 40 гаруй том жижиг чацаргана боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн нийт хүчин чадлын хэмжээ нь жилд 5,000 орчин тонн түүхий чацаргана боловсруулах боломжтой. Үүнээс үзвэл “Хархорин” ХК нь дангаараа Монгол Улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдийн нэг жилийн түүхий эдийн хэрэгцээний 25%-ийг хангах бололцоотой.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

2019 оны 12-р сараас эхлэлтэй Covid 19 цар тахал, үүний эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөл хорио, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хил хаах болон бусад арга хэмжээнээс үүдэж дэлхийн эдийн засаг, тэр дундаа импортын бүтээгдэхүүн, түүхий эдээс хамааралтай Монгол Улсын эдийн засаг ихээхэн хохирол амсаад байна. Энэ нь хөдөө аж ахуй, үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэний салбарт багагүй хүндрэл, сорилтуудыг бий болгож байгаа. Тариаланч нарын хувьд талбай дээр ажиллах хүчний дутагдалд орох, бүтээгдэхүүнээ борлуулах, тээвэрлэх, үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд нийлүүлэхэд хүндрэл учрах, санхүүжилтгүй болох зэрэг олон асуудлууд гарч ирж байна.

Цаашид цар тахлын нөлөө ямар хугацаанд үргэлжлэх, вакцинжуулалт үр дүн өгөх эсэх зэрэг нь тодорхой бус байсаар байна. Үүн дээр коронавирус нь мутацид орж өөр төрлийн хувилбарууд гарч байна.

Жимс жимсгэнэ, чацарганы зах зээлийн хувьд тус жимсний өөрийнх нь онцлог шинж чанар, хүний биед ач тустай амин дэм, бодисоор баялаг, ялангуяа хүний дархлааг дэмждэг шинж чанараас нь болоод чацаргана жимс, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хүмүүс илүү сонирхож хэрэглэгчид нэмэгдэж байгаа. Үүнийг дагаад тухайн бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ ихсэх хандлагатай байгаа.

“Хархорин” ХК нь өөрийн чацарганы талбай дахь жимсний моднуудад арчилгаа, тордлогоо хийх, зэрлэг устгах, усалгаа хийх, жимс хураах зэрэг ажилд өөрийн үндсэн ажилтан ажиллагаадаас гадна нэмэлт ажиллах хүч авч ажиллуулсаар ирсэн. Үүнд оюутан сурагчид,

Хархорин сумын иргэд, БХЯ-ны цэргийн анги нэгтгэлүүдээс цэргийн албан хаагчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хүмүүжигчдийг авч ажиллуулдаг.

Гэвч 2020 онд Covid 19 цар тахал, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хөл хорио тогтоох зэргээс үүдэн гаднаас шаардлагатай ажиллах хүч авч чадаагүй. Түүнчлэн 2020 оны зун Хархорин сумын нутагт бороо хур бага, гантай байсан, Орхон голын усны түвшин бага байсан. Эдгээр шалтгаанаас үүдэн 2020 онд төлөвлөж байсан чацарганы ургацаа авч чадаагүй. Энэ нь манай компанийн үйл ажиллагаа, санхүүд муугаар нөлөөлж байна. 2021 онд байгаль цаг агаар тааламжтай, жимст цэцэрлэгт технологийн дагуух ажлууд, ургац хураалт хийх үед цар тахлаас үүдэлтэй хөл хорио тогтоохгүй, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхгүй байх тохиолдолд сайн ургац авах боломжтой юм.

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:

П.Бишрэл	ТУЗ-ийн Дарга
Л.Хосбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн
О.Төмөрбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга
Ц.Энх-Амгалан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
Ж.Энхтөр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга
П.Учрал	ТУЗ-ийн ердийн гишүүн
Б.Амарсанаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
С.Амгалан	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
Б.Бүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшууллын хороодын гишүүн
Р.Саранцэцэг	Гүйцэтгэх захирал
Б.Ганбат	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Л.Бямбасүрэн	Ерөнхий агрономич
Д.Дашмаа	Ерөнхий нягтлан бодогч

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

Д.д	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Сүрэнжавын Пүрэв	377,660	70.00%
2	Монгол Улсын хуулийн этгээд “Селус Номадс” ХХК	102,521	19.00%

8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт (2021 оны 2-р улирлын байдлаар)

8.1. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагч “Хархорин” ХК нь 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2021 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2021 оны 06-р сарын 30-ны өдрийн хооронд тайлант хугацаанд өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь “Хархорин” ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой. Линк нь <http://mse.mn/uploads/finance/17920212report.pdf>

“Хархорин” ХК-ийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 8,138.7 сая.төг болсон.

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт үндсэн хөрөнгө элэгдэл хассан дүнгээр 1,705.8 сая төгрөг, түүнчлэн биологийн хөрөнгө 1,082.8 сая. төгрөг болж эргэлтийн бус хөрөнгийн дүн 2,788.6 сая төгрөг болсон.

2021 оны эхний хагас жилээр мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө 1,263.3 мян.төг, авлагын нийт дүн 558,671.4 мян. төг, бараа материал нийт 318,083.9 мян.төг, бусад эргэлтийн хөрөнгө (дуусаагүй үйлдвэрлэл) 3,175,187.3 мян.төг, бусад санхүүгийн хөрөнгө 1,296,917.6 мян.төг болж эргэлтийн хөрөнгийн дүн 5,350,123.5 мян. төгрөг болсон.

Урт болон богино хугацаат өр төлбөрийн хувьд 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн дагуу “Хархорин” ХК нь нийт 0.0 мян.төг-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй, богино хугацаат өр төлбөр 9,157,560 мян.төг, нийт 9,157,560 мян.төг-ийн өр төлбөртэй гэж гарсан.

Үр дүнгийн тооцоо

Тайлант хугацаанд:	Борлуулалтын нийт орлого:	72,435.4 мян.төг
	Борлуулалтын өртөг:	68,678.9 мян.төг
	Борлуулалтын ашиг:	3,756.5 мян.төг
	Үйл ажиллагааны бус орлого:	49,160.5 мян.төг
	Ерөнхий ба удирдлагын зардал:	55,355.9 мян.төг
	Бусад зардал:	22,038.1 мян.төг

болж тайлант үеийн цэвэр ашиг татвар төлөхийн өмнөх байдлаар хасах 24,477 мян.төг болсон. Үүнээс орлогын албан татварын зардал 0.0 гэж үзвэл, тайлант үеийн алдагдал татварын дараах дүнгээр 24,477 мян.төг болно.

8.2. “Хархорин” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн тухай

Компани нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын компани болох “Дөлгөөн хайрхан уул Аудит” ХХК аудитын компаниар өөрийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн болно.



Зураг 1. Хараат бус аудиторын дүгнэлт

Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, товилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, компани татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар харваат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.
- Компанийн дотоод хяналтын үр ашингтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн
- Компанийн тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан

Зураг 2. Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай" хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.



ДӨЛГӨӨН ХАЙРХАН УУЛ
АУДИТ ХХК

Зураг 3. Хараат бус аудиторын дүгнэлт (үргэлжлэл)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ны байдлаар

	(төгрөгөөр)	
	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,382,022.07	1,370,306.92
Авлага	595,130,935.70	563,309,423.14
Бусад санхүүгийн хөрөнгө	1,296,917,582.50	1,296,917,582.50
Бараа материал	391,668,253.93	322,116,406.86
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	2,636,360,047.32	3,056,833,580.15
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Нийт эргэлтийн хөрөнгө	4,921,458,841.52	5,240,547,299.57
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө (төвэр)	1,891,916,006.46	1,705,771,933.46
Биологийн хөрөнгө	1,082,788,304.40	1,082,788,304.40
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө	2,974,704,310.86	2,788,560,237.86
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,896,163,152.38	8,029,107,537.43
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	8,526,418,460.87	9,023,506,841.42
Урт хугацаат өр төлбөр	70,000,000.00	-
Нийт өр төлбөр	8,596,418,460.87	9,023,506,841.42
Эздийн өмч		
Дүрмийн сан	836,220,266.63	836,220,266.63
Хуримтлагдсан ашиг (аллагдал)	(1,536,475,575.12)	(1,830,619,570.62)
Нийт эздийн өмч	(700,255,308.49)	(994,399,303.99)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН	7,896,163,152.38	8,029,107,537.43

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Зураг 4. "Хархорин" ХК-ийн 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ны байдалвар

	(төгрөгөөр)	
	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Борлуулалтын орлого (нэвэр)	887,637,717.55	399,041,508.85
Борлуулалтын өртөг	866,851,404.05	332,740,663.37
Нийт ашиг (алдагдал)	20,786,313.50	66,300,845.48
Бусад орлого	59,041,699.76	150,733,992.95
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	182,667,465.01	171,361,798.31
Санхүүгийн зардал		
Бусад зардал	44,186,291.45	339,817,035.62
Бусад олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(147,025,743.20)	(294,143,995.50)
Орлогын татварын зардал		
Татвар дараах ашиг (алдагдал)	(147,025,743.20)	(294,143,995.50)
Зөгсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(147,025,743.20)	(294,143,995.50)
Тайланг үеийн нэвэр ашиг (алдагдал)	(147,025,743.20)	(294,143,995.50)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Орлогын нийт дүн	(147,025,743.20)	(294,143,995.50)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн санхүүг хэсэг болно.

АБГ.ОА.26

Зураг 5. "Хархорин" ХК-ийн 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан орлогын тайлан

"Хархорин" ХК

Аудитлагдсан тайлан


ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ны байдлаар

(төгрөгөөр)

	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 сарын 31	836,220,266.63	(1,536,475,575.12)	(700,255,308.49)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-
Залруулсан үлдэгдэл	836,220,266.63	(1,536,475,575.12)	(700,255,308.49)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(294,143,995.50)	(294,143,995.50)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-	-
Зарласан ногдол ашиг		-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-	-
2020 оны 12 сарын 31	836,220,266.63	(1,830,619,570.62)	(994,399,303.99)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.




Зураг 6. "Хархорин" ХК-ийн 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 12 сарын 31-ны байдлаар

	(төгрөгөөр)	
	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,937,146,980.09	597,255,201.30
Мөнгөн орлогын дүн	718,298,949.16	162,974,342.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,218,848,030.93	434,280,859.30
Бусад мөнгөн орлого	1,937,661,712.46	597,266,916.45
Мөнгөн зарлагын дүн	199,386,440.00	90,158,690.00
Ажиллагчдад төлсөн	88,698,168.20	7,291,045.00
Нийгэмийн даатгалын байгууллагад төлсөн	10,189,700.00	7,405,491.00
Бараа материал худалдан авахад төлсөн	9,994,957.00	9,609,769.37
Ашиглалтын зардалд төлсөн	91,522,694.00	60,012,478.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	155,243,555.00	45,216,611.00
Хүүний төлбөрт төлсөн	27,437,196.00	
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн	1,355,189,002.26	377,572,832.08
Бусад мөнгөн зарлага	(514,732.37)	(11,715.15)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(514,732.37)	(11,715.15)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,896,754.44	1,382,022.07
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,382,022.07	1,370,306.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,382,022.07	1,370,306.92

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайвнгийн санхүүг хэсэг болно.



Зураг 7. "Хархорин" ХК-ийн 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

8.3. Татварын тайлангийн тухай (2021 оны 2-р улирлын байдлаар):

“Хархорин” ХК нь 2021 оны 01 болон 02 дугаар улирлын татварын тайлангуудаа Монгол улсын Татварын багц хууль, тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд гаргаж цахимаар харьяа татварын байгууллагад илгээж баталгаажуулсан болно.

9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Тайлант хугацаанд “Хархорин” ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл

2021 оны 03 сараас эхлэн усалгааны суваг шуудууны тоног төхөөрөмжийг засаж сэлбэх, өөрөө явдаг болон дүүжин, чиргүүлэн машин техник, тоног, төхөөрөмжүүдийг өвлийн тэг зогсолтоос гаргахаар усалгааны бригад, засварын газрын жолооч, механикжуулагчдыг ажилд нь оруулан засварын ажлуудыг хийлгэсэн.

Компанийн газар тариалангийн болон жимст цэцэрлэгийн талбайн ажил 2021 оны 3 сарын 25-аас эхлэн одоог хүртэл явагдаж байна.

2021 оны 5 сараас эхлэн чацаргана, хайлаас, шар хуайс болон бусад модны суулгац гаргаж өөрийн цэцэрлэгийн нөхөн тариалалт, түүнчлэн гадна байгууллага, хувь хүмүүст бага хэмжээгээр нийлүүлсэн.

Компанийг өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирлын зүгээс шуурхай удирдлагаар байнга ханган, тулгамдсан асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.

2021 оны 04 сарын 05-ны өдөр компанийн бүх ажилчдын хурал хийж энэ оны ажлын төлөвлөгөөг танилцуулснаар энэ жилийн ажил эхэлсэн. Агрономич, ЗАА-н ажилчдын хүчээр жимст цэцэрлэгийн талбайд тархсан хортон мэрэгчдийн эсрэг тэмцэх бромациолонтой будаагаар хорт өгөөш бэлтгэж найруулах ажил эхэлсэн. 4-р сарын 15-ны өдрөөс эхлэн 6 хоногийн хугацаанд нийт жимст цэцэрлэгийн талбайд хортон мэрэгчдийн эсрэг хорт өгөөшийг мэрэгчдийн үүрний амсар, байнга явдаг жим зам дээр тавих ажил хийгдсэн.

4-р сарын 19-ний өдрөөс 5 хоногийн хугацаанд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадын цэцэрлэгчдийн хүчээр жимст цэцэрлэгийн талбайд талбайн хогийг цэвэрлэсэн ба энэ ажилд 1-р бригадын 4 цэцэрлэгчийн 4 хүн/өдөр хүчийг, 2-р бригадын 3 цэцэрлэгчийн 6 хүн/өдөр хүчийг ашигласан.

4-р сарын 26-ны өдрөөс эхлэн нийт жимст цэцэрлэг хариуцсан цэцэрлэгчид болон компанийн бусад ажилчдын хүчээр суваг цэвэрлэх ажилыг эхлүүлж нийт 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

5-р сарын 10–14-нд жимс хөлдөөх хөлдөөгчийн их цэвэрлэгээ, барилгын дотор хураалттай байсан бара, материалыг хураах, өөр агуулахад зөөвөрлөх, хөлдөөгчийн тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах, зүгшрүүлэх, засаж сэлбэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

5-р сарын 17–20-нд дөрвөн өдрийн турш талбайн заагуудад хортон мэрэгчдийн эсрэг хорт өгөөш тавьж тэмцэх ажил хийгдсэн ба энэ ажилд нийт жимст цэцэрлэг хариуцсан бригадуудын хүн хүчийг мөн авч ажиллуулсан. Энэ ажилд 1-р бригадын 6 цэцэрлэгчийн 9 хүн/өдөр хүчээр 49,8 га талбайд, 2-р бригадын 4 цэцэрлэгчийн 4 хүн/өдөр хүчээр 24 га талбайд, 3-р бригадын 6 цэцэрлэгчийн 8,5 хүн/өдөр хүчээр 47,5 га талбайд, 4-р бригадын 5 цэцэрлэгчийн 7,5 хүн/өдөр хүчээр 41,5 га талбайд буюу агроүйлдвэрлэлийн 4 бригадын 21 цэцэрлэгчийн 29 хүн/өдөр хүчээр 162,8 га талбайд хорт өгөөш тавьж тэмцсэн.

5-р сарын 20–23-ны хооронд бойжуулгын 5-Б талбайд 2015 онд тариалагдсан байсан, хөгширч актлагдсан чацарганы суулгацыг трактороор үндсийг нь хавж зөөлрүүлээд гараар талбайгаас түүж аван био хаягдал хураах талбарт зөөж асгах ажил хийгдсэн.

5-р сарын 23-25-нд дээрх хөгширч актлагдсан суулгацаас нь чөлөөлсөн 5Б бойжуулгын талбайн зүүн үзүүрээс гурван удаагийн үйлдлээр 3.2 га талбайг ПУМА трактороор эргүүлэн хагалж, борнойдож тэгшлээд ЮМЗ-6 трактор болон 3-р бригадын цэцэрлэгчдийн хүчээр хайрцаг хийх шуудуу татуулаад, энэ жилийн бойжуулгын хайрцаг хийх ажил эхэлсэн.

6-р сард бойжуулгын талбайгаас ковшоор суулгац ухаж гаргаад ажилчдын хүчээр талбайгаас түүж, ялгаж, тоолж, боож багцлан гадагшаа ба дотооддоо нөхөн тариалалтад нийлүүлсэн. Энэхүү ажилд бригадуудын 4 цэцэрлэгчийг оролцуулсан.

6-р сард жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээх, жимст цэцэрлэгийн чацарганы модонд тоос хүртээхэд зориулж хөгширч актлагдсан эр модны суулгацаас тоос хүртээх мөчир хайчлан тоос хүртээлт хийж буй бригадуудад нийлүүлэх, гадагш нийлүүлэх суулгацыг түр хадгалалтаас ухаж гарган ялган тоолж ангилаад, шошго зүүн боож ачих, усалгаа хийх шуудууг нь сэргээн засах, усалгаа хийх, тракторт чиг татаж зогсох зэрэг ажлуудыг хийсэн.

6-р сард бригадуудын 5 цэцэрлэгчийн хүчээр чацарганы талбайд усалгааны туслах шуудуунуудыг нь шинээр сэргээн ухаж гаргах, гар аргаар услах ажлуудыг хийж гүйцэтгэж байсан.

11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:

“Хархорин” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах өөрийн байранд, хурлын танхимд хуралдуулсан.

Тус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн хурлаараа авч хэлэлцээд холбогдох шийдвэрийг гаргасан. Хурлын мэдэгдлийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Тус ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-с бүртгэлийн өдрөөр гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авсан болно.

Тус судалгааны дагуу тус бүр нэг саналын эрх бүхий нийт 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 579 хувьцаа эзэмшигчид 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй байсан. Эдгээр хувьцаа эзэмшигчдээс нийт 378,146 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 6 хувьцаа эзэмшигч тус хуралд оролцож саналаа саналын хуудсар өгсөн болно.

Хурлын ирц 70.1 хувь болсон.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон эдгээр асуудал тус бүрээр хуралд оролцсон саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын тоог, хувь зэргийг дараах хүснэгтээс үзнэ үү:

Ердийн аргаар авсан санал хураалтын дүн

Д/д	Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,146 (100%)	0	0
2	Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,146 (100%)	0	0
3	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах	378,146 (100%)	0	0
4	Компанийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас авах, үүнд шаардагдах барьцаа хөрөнгийн тухай	378,146 (100%)	0	0

Жич: хүчингүй саналын хуудас гараагүй болно.

Кумулятив аргаар авсан санал хураалтын дүн

Д/д	Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд	Ирүүлсэн кумулятив саналын нийт тоо	Тухайн нэр дэвшигчид өгсөн кумулятив саналын тоо, хувь
1	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох		
1.1	ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох	2,268,876 (100%)	
1	Пүрэвийн БИШРЭЛ		378,146 (16.67%)
2	Жаргалын ЭНХТӨР		378,146 (16.67%)
3	Цэрэндолгорын ЭНХ-АМГАЛАН		378,146 (16.67%)
4	Пүрэвийн УЧРАЛ		378,146 (16.67%)
5	Ойдовсүрэнгийн ТӨМӨРБААТАР		378,146 (16.67%)
6	Лхагвасүрэнгийн ХОСБАЯР		378,146 (16.67%)
1.2	ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох	1,134,438 (100%)	
1	Сандагийн АМГАЛАН		378,146 (33.33%)
2	Баатарын АМАРСАНАА		378,146 (33.33%)
3	Баттулгын БҮРЭН		378,146 (33.33%)

“Хархорин” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолууд, хурлын тэмдэглэлийг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

12. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн шийдвэрүүд

2021 оны эхний хагас жилийн хугацаанд “Хархорин” ХК-ийн ТУЗ-с дараах шийдвэрүүдийг гаргасан болно:

Тогтоол, шийдвэрийн Огноо	Товч утга	Тогтоол шийдвэрийн агуулга
2021.02.05	Ногдол ашиг хуваарилахгүй тухай	ТУЗ-с Компанийн тухай хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг хэлэлцээд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу компани нь 294.1 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбоотойгоор 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.

2021.03.12	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04-р сарын 24-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэж хурлаар хэлэлцэх асуудлууд, саналын хуудасны загвар болон Компанийн тухай хууль, СЗХ-ны холбогдох журамд заасны дагуу хурал зарлан хуралдуулахтай холбоотой бусад асуудлуудыг хэлэлцэж баталсан.
2021.05.28	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг томилох	“Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2021 оны 4-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгосонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэшүүлэх хорооны гишүүд, даргыг томилсон болно.

13. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

“Хархорин” ХК-ийн 5% ба үүнээс илүү хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд тайлант хугацаанд буюу 2021 оны эхний хагас жилд өөрчлөлт ороогүй болно.

5% ба үүнээс дээш хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тасалбар болгож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-с гаргуулан авсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалганы дагуу дараах байдалтай байна. Үүнд:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь
1	С.Пүрэв	377,660 (70.00%)
2	Селус Номадс ХХК	102,521 (19.00%)
3	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид (нийт 573)	59,334 (11.00%)
ДҮН		539,515 (100%)

“Хархорин” ХК, 2021 он